

Цэвээнравдан хунтайж Зүүн гар
улсын хаан суусан нь

Доктор /PhD/, дэд профессор И. Саруул

Монголын түүхэнд нэр алдраа үлдээсэн төр улс, нийгмийн томоохон зүтгэлтэн бол Цэвээнравдан хаан билээ. Түүнийг ойрад түмнийг захирч байсан цагт Зүүн гарын улс хөгжил цэцэглэлтийнхээ оргилд хүрч, Төв Азийн өндөрлөгт улс төр, цэрэг байлдааны хүчээр тун нөлөөтэй байсныг Монголын түүхэнд тэмдэглэжээ. (1.т.129.)

Өнөөдрийн байдлаар Цэвээнравдан хааны намтар, үйл ажиллагааг сэдэвлэсэн эрдэмтэн судлаач хараахан үгүйн учир нь түүхэн сурвалж, баримт сэлт ховор байгаатай холбоотой юм. Харин судалгаа шинжилгээнийхээ хүрээнд хамруулсан монгол эрдэмтдийн хамтын бүтээл БНМАУ-ын түүх (Боть П), оросын И.Я. Златкин (3), Б.П.Гуревич (8) нар, хятадын Н. Алтаншаа (5), Намсрай (4) нарын бүтээлүүд байна. Иймд зохиогч сэдэвлэн 2001 онд Цэвээнравдан хаан (6) номыг хэвлүүлээд байна. Гэсэн ч эдгээр нь Цэвээнравдан хааны үе буюу ХҮП зууны сүүлч ХҮШ зууны эхэн үеийн Монголын түүхийг лавшуулахад хангальгүй тул судлах эрэлт хэрэгцээ, олны хүртээл болгох шаардлагатай байна.

Цэвээнравдан бол ойрадын чорос аймаг угсааны гаралтай, түүний эцэг Сэнгэ хаан Баатар хунтайжийн тавдугаар хөвгүүн болно. 1671 онд Сэнгэ хаан эх нэгтэй ах Сэцэн, ойрадад нөлөө бүхий Зодов баатар наратай Зүүн гар улсын эрх мэдэл, өмч хөрөнгөө булаалдах тэмцэлд ялагдаж Сэцэнд алагджээ. Түвшдэд шавилан сууж байсан Сэнгийн дүү Галдан энэ үймээний чимээг олж мэдмэгцээ шашны номоо орхиж, Зүүн гар улсдаа даруй буцаж ирээд ах Сэнгийн язгуурын харьяат албатуудыг хураан Сэцэний хүчийг цохин устгаж, Зодов баатрыг Хөх нуурт хөөн зайлцуулсан байна. Ингээд Цэвээнравданы дүү Сономравданг Зүүн гар улсын хаанд өргөмжилөх гэтэл Цэвээнравдан, Сономравдан хоюулаа нас бага балчир учирт төрийн эрхийг Галдан бошгот гартаа авч ойрадын хааны орыг залган суужээ. Цэвээнравдан тэхэд зургаан настай байжээ.

1679 онд Галдан бошгот Алтайн ууланд нутаглаж байхдаа Цэвээнравдандаанд ахын өнчин хөвгүүн гэж ойрадын хаадын өргөөний нутаг Бор талыг хувь отгоор шагнаж суулгасны дээр Хами, Турфан хотуудыг давхар харьяалуулан захириулж, албан татварыг түүнд хувьд оноон олгох болжээ (2.т.111.). Цэвээнравдан тэхэд арван дөрвөн настай байсан бөгөөд Галдан бошготоос ойрад даяар нэр хүнд бүхий Сэнгэ ахынхаа хүүхдүүдийг асран хамгаалж буй дүр эсгэж олны санаа сэргэлийг өөртөө татаж байжээ.

1682 онд Цэвээнравдан 17 нас хүрч нэгэнт эрийн цээнд хүрчээ. Ойрад угсааны нэгэн салбар хошоод нь чорос аймагтай угаас ураг садны харилцаатай явж ирснээ баталгаажуулж, урьд өмнө хошоодын Очирт сэцэн ханы хөвгүүн Галдамба тайж өөрийнхөө их хүүхэн Ануудария Сэнгэ хунтайжид ураглуулж, бага охин Ахайгаа Цэвээнравдантай холбооор хэлэлцсэн байжээ. Тохиролцсон ёсоор Ахай хүүхнийг хүргэж ирэхэд Галдан бошгот түүнийг Цэвээнравдантай ураглуулсангүй, харин өөртөө хатан болгон буулгажээ. Чухам энэ үед авга ах Галдан бошгот хаан, ач хүү Цэвээнравдан нарын хооронд гомдол үүсчээ (5.т.183-184.).

1683 онд Тэнгэр уулын өмнө суулгасан Цагаадай хааны үрсийн хоёр султан тэрсэлж, Галдан бошготын тавьсан цагаан малгайтны тэргүүн Аwig хожиг унагааж, Бага хүрээний лам нарыг галзуу мэт уулгалан дайрч Зүүн гар улсаас тусгаарлахыг оролдоход Аwig хож бачимдан арга буюу Зүүн гараас тусламж гүйжээ (3.т.332.). Галдан бошготыг Халхыг дайлах цагийг далимдуулан араар нь үймээн дэгдээн өдөөсөн хэрэгт ихэд уурлаж, Цэвээнравданг тэдэнтэй тооцоо хийхийг зарлигдсан даруй цэрэг дайчилж, хоёр султаныг санаандгүй байхад нь хиартал цохижээ (4.т.12.). Энэ хэрэг явдлаар Цэвээнравданы төрөлхийн авьяас билэг, цэргийн ур чадвар тодорч ойрад даяар нэр хүнд нь цууриатжээ (5.т.15.). Мөн Цэвээнравданд Тэнгэр уулын өмнөх орныг чангалаан

захирах, хүчээ зузаатгахад сайхан тохиол болж, Галдан бошготтой тэмцэх суурийг тавьжээ (6.т.27.).

1688 оны Х сарын 7-нд Галдан бошгот хаан ойрадын их цэргийг дагуулан манжийн дарангуйллын эсрэг байлдахаар Ховдод ирж өвөлжсөн байна. Ховд хязгаар нь Алтайн нурууны зүүн талд Завханы баруун этгээдэд орших тул дайн байлдааны арга бодлогод маш чухал байршилтай газар байв. Тиймээс түшиц газар болгож, Зүүн гарын төрийн удирдлага, цэргээ төвлөрүүлж, тэндээс гол үйл ажиллагаагаа удирдан өрнүүлжээ. Тэхэд Цэвээнравданг өөрийн дэргэд барьж байхын тулд овжин заль гаргаж түшмэд ноёдын дундаас хамгийн чадвар сайтай, итгэлтэй залгамжлагчаар тунхаглаж, 1689 оны хавар Ховдын бүгдийн захирагчаар тохooсон байна (4.т.111.). Үнэн хэрэг дээрээ Галдан бошгот өөрийн итгэлт дөрвөдийн Алдар тайжид үндсэн ажиллагааг нь хариуцуулсан болохоор Цэвээнравдан бас л ёс төдий байр сууринд байв.

Монголын түүхийн нэгэн зангилаа асуудал бол Галдан бошгот, Цэвээнравдан нарын зөрчлийн асуудал билээ. Тус сэдвийг хөндсөн эрдэмтдийн бүтээлд зөрчил чухам ямар шалтаг шалтгаан дээр үндэслэж, хэдийд эхэлсэн, хэрхэн өрнөсөн тал дээр санаа бодол зөрчилдэж буй. Шалтгааны сурвалж нь төрийн эрх мэдэл, хаан ширээг эзлэх ойрадын улс төрийн хүндхэн тэмцэл бөгөөд Галдан бошготын хаанчлалын үеийн ойрадын түүхийг нягталбал Цэвээнравдан, Сономравдан нас балчир байхад нь Зүүн гар улсын хаанд өргөмжилсөн дүр эсгэжээ. Эс тэгвээс өөрөө ойрадын ноёдын дэмжлэгийг олж хаан орыг эзэлж чадахгүй байв. Тиймээс ах Сэнгэ хааны итгэлт шадруудыг төрийн эрхнээс аажмаар шахан гаргаж, Цэвээнравдан, Сономравдан нарыг ганцаардуулах арга хэмжээг авч байжээ.

Зөрчил өрнөж эхэлсэн талаар өвер монголын судлаач Алтаншаа 1679 онд хошоодоос Ахай хатныг Цэвээнравданд ураглуулах явдлаар авга ах Галдан бошгот, ач хүү Цэвээнравдан нарын хооронд гомдол үүсчээ (5.т.183-184.), мөн өвер монголын Намсрай 1683 онд Турфан дахь бослогын үеэр эхэлж Хоёр султаны үймээн цар хүрээгээрээ тийм ноцтой биш боловч түүнээс гарсан үр дүн, хор уршиг нь Цэвээнравданд тун хортойгоор хүнд тусчээ (8.т.112.) гэжээ. Цаг хугацааны хувьд холдохгүй ба тэдний олж үзсэн сурвалжаас тайлбар нь шалтгаалжээ. Монгол, орос, бусад орны судалгааны бүтээлүүдэд уг асуудлыг одоогоор хөндөөгүй байгаа нь сурвалж баригдаагүйтэй холбоотой болбуу. Зүүн гар улсын түүхийн өрнөлтөөс ажиглавал Ахай хатныг ураглуулах үеэр хоёр их хүний хагарал зөрчлийн суурь тавигдаж, Турфаны хэрэг явдлаар хурцдах шатандаа оржээ.

Цэвээнравдан зөрчлийг тэмцэлд хүргэхгүй байхыг хичээж, Зүүн гар улсын ашиг тусыг бодож, Галдан бошгот хааны үйл хэрэгт үнэн сэтгэлээсээ зүтгэж иржээ (3.т.246.). Нэгэөтэйгүүр зөрчил гомдол гаражад Цэвээнравдан хорлогдсон эцэг хаан Сэнгийг залгамжлах санааг өвөртлөх болж, гагцхүү Галдан бошготын өмнө хүчин мөхөсдөх учир байдлыг хянаж далдуур тэмцэх бэлтгэлээ базааж суужээ.

Энэ хир Цэвээнравдан 24 настай, Сономравдан нар хувиараа өмч хөрөнгөтэй, албат харьяаттай, ойрадын ард түмний дунд нэр хүнд бүхий их тайж болцгоож, Галдан бошготтой тэмцэх аятай тохиолыг хүлээн байжээ. Ойрад тайж ноёдын дотроос зөвхөн тэр хоёрын хэн нэг нь хорлогдсон эцэг Сэнгэ хааны орыг залгаж, Зүүн гар улсын эзэн болох бүрэн эрхтэй байжээ. Ойрадын түмэн олон ч Галдан бошготын хүчирхийлэл, дайчин бодлогод дургүйцэн Цэвээнравдан, Сономравдан нарыг хүрээлэх болов. Гэвч Галдан бошгот ойрадын хааны суудлыг хараахан сүлтгах байтугай огтхон ч хүсэлгүй байв.

Тун удсанчгүй тэмцэл аяндаа өрнөж эхэлжээ. Нэг талаас Галдан бошгот хаан, нөгөө талаас Цэвээнравдан, Сономравдан нарын зөрчлийг туйлбаргүй бялдууч этгээдүүд овжин ашиглах болсон. Сэнгэ хааны гуравдугаар хөвгүүн Данзан-Омбо Цэвээнравдан ахынхаа авьяас чадвар, нэр хүндэд атаархаж, хуримтласан эд хөрөнгөнд шунаж, уулаас хаан суурийг эзлэх атгаг санаа өвөртөлж, Цэвээнравданг урвах санаатай гэж Галдан бошгот хаанд худал хов хүргэж амжсанаар байдлыг хүндрүүлэв. Мөн Ноён

гэлэн гэгч бялдууч этгээд олны дунд Цэвээнравданг хаанаасаа урвах далд санаатай гэсэн худал хуурмаг цуурхал тарааж, Галдан бошготод сэм гүтгэсэн байна (4.т.112.).

Галдан бошгот хаан тэр даруй Түвдээс түүнд томилон ирүүлсэн зурхайч Нэйцэн-Омбод мэргэ үзүүлсэнд **Чиний ач Сономравдан болон Цэвээнраавдан нар хоюулаа Зүүн гар улсын төрийн эрх мэдлийг булаан авах санаа агуулсан тул түргэн арилгавал сайн** (4.т.112.) гэсэн төлөг буулгажээ. Энэ мөчөөс Галдан бошгот хаан Цэвээнравдан, Сономравдан ах дүү нарыг шууд хардан болгоомжилж, Данзан-Омбо, Ноён гэлэн зэрэг ноёдын хорон санаагаар замаасаа зайлцуулахыг бодолхийжээ.

1689 оны хавар Цэвээнравданг түр эзгүй байхад нь Галдан бошготын зөвшөөрснөөр Данзан-Омбо Сономравдан их тайжийг сэмхэн хороосон байна. Галдан бошготоос Цэвээнравданд дүү Сономравданы үхлийн талаар **Дүү чинь гэнэтийн өөчинөөр нас бараа** (5.т.184.) гэж хэлжээ. Цэвээнравдан үүнд итгэсэнгүй, харин амь насанд нь аюул учирч, тэмцэл ноцсоныг ухаарчээ. Тэр өдөр нь Бага хүрээний Аржив хэмээх нэгэн лам **Чиний дүү нууцаар хорлогдов. Чи хэрэв золгүй бол лавтай алагдах болно** (5.т.184.) гэж үнэнийг илтгэн анхааруулсан байна.

Байдал ингэж халтай болж тэмцэл өрнөхөд Цэвээнравдан Галдан бошготын захиргаанаас даруй салан тусгаарлахаар буцалтгүй шийджээ. Сэнгэ хаанд зүтгэж явсан хуучны итгэлт түшмэдийг эрж олоод тэдэнтэй нүүр тулан илэн далангүйгаар өөрийн санасан бодлоо хэлж зөвлөлдсөн байна. Тэхэд эцгийнх нь дотны анд долоон түшмэл Цэвээнравданы санааг зөвтгөн дэмжиж, түүний төлөө амь биеэ хайрлалгүй шударгаар зүтгэхээ тангараглажээ. Тэдний дэмжлэг тусын ачаар Галдан бошготоос салах бэлтгэлийг хоромхон зуур гүйцээгээд 1689 оны хавар 5000 албатаа дагуулан Ховдоос хөдөлжээ. Тэр зуур Ховдод хадгалагдаж байсан Галдан хааны үнэт зүйлсийг ачаалан зөөвөрлөхийн хамт түүнд ураглуулсан Ахай хатнаа бас булаан авч баруун зүг Хар Азаргын шилийг даван зугатжээ (7.т.95.).

Цэвээнравданг оргон зайлсныг мэдмэгцээ Галдан бошгот биеэрээ 2000 хөнгөн морьт цэрэг хөдөлгөж, Өрөмчийн зүүн биө дэх Улаан-Ус гэдэг газарт гүйцээд Үржжав зайнсанг томилж Цэвээнравданг самуун дэгдээлгэсэн ял асуулгаж, урvasан олныг тушаан бууж өгөх зарлиг буулгажээ. Тэхэд Цэвээнравдан Галдан бошготод хорлогдсон эцэг Сэнгийн орыг зүй бусаар тавьж өгөхгүй байгаа, Ахай хатныг ёс бус булаасан, дүү Сономравданг шалтгаангүйгээр санаатай хороосон зэрэг шалтгаануудыг сануулж, ямар ч найрамдал дагаар явах тухай хэлцэл байх ёсгүйг мэдүүлэсэн бололтой (3.т.304.). Цэвээнравдан хунтайж баатар эрсийнхээ хүчээр Галданы цэргийг хиартал цохиж, бараг бутран сөнөх шахсаны дээр өлсөн өлбөрч ухэхийн туйлд хүрч, ноёд харьяатуудын дийлэнх хэсэг нь Цэвээнравданд дагаар орцгоосон байна (5.т.185.). Үргэлжлүүлэн байлдах нь Галдан бошготод хүч хүрэлцэхгүй тул Ховд руу зугатжээ.

Улаан-Усны газраас Цэвээнравдан өөрийн захиргааны Турфанд очиж хэсэг хугацаанд хүнс хүчээ бүртгэн цэрэг морио нөхвөрлөн зузаатгаж (7.т.95.) байгаад Галдан бошготыг Ховд руу хөдлөхөд Цэвээнравдан Зүүн гартаа буцаж Бор талдаа суурьшчээ (4.т.113.). Түгшүүрт цаг үед амь биеэ огоорон Цэвээнравданд үнэнчээр зүтгэсэн эцэг Сэнгийн хуучин долоон түшмэлээ **нөхөр** хэмээн олон түмэнд алдаршуулж, тэдний үрс ач нарыг долоон удаагийн үхэх ялаас хэлтрүүлэн тогтоожээ (4.т.113.).

Бор тал ус бэлчээр сайтай өргөн уудам тал нутаг болохоор малын тарга тэвээрийг авахуулж хүчээ сэлбэхэд таатай, цэрэг-дайны тактик стратегийн зохион байгуулалттай чухал газар болно. Тиймээс ч ойрадын улс төр, соёл иргэншлийн суурьтай ажээ (5.т.185.). Энд Цэвээнравдан Галдан бошготын сарнин бутарсан ард иргэдийг хурааснаар харьят нь 40000 хүрч, Или, Тарвагатай, Ховог сайр, Эрчис мөрний сав газрыг цөм эрхшээлдээ багтаажээ (7.т.95.). Чухам энэ үеэс Цэвээнравдан Зүүн гарын улсыг захирах болов. Галдан бошготын харьят мөн 40000 орчим (3.т.301.) байсан нь өрсөлдөгч талуудын хүч ойролцоо тэнцжээ.

Цэвээнравданг Ховдоос оргон зайлснаас болж тэнд үймээн самуун дэгдэхэд хүрчээ. Галдан бошгот Улаан-Уснаас яаравчлан Ховдод хүрч ирсэн нэгэн шалтгаан нь бөгөөд захиргааныхаа албатуудыг ямар ч шалтгаангүйгээр урван тэрсэлсэн хэрэгт

холбогдуулан олон хүнийг хэрэгт ялласан байна. Түүний энэ байдлыг далимдуулж туйлбаргүй этгээдүүд нягт хүрээлэн, Ноён гэлэн зусар бялдуучийг өндөр зөвлөгч болгожээ (4.т.114.).

Ноён гэлэн бол лам гаралтай, Бага хүрээний хуваргуудын итгэл хүндийг алсан, шалтаг гарвал тус хүрээний лам нарыг дарахыг хүсдэг байв. Тэр Бага хүрээний лам нарыг биеэрээ байцаагаад Сономравданг алсан мэдээг Цэвээнравданд хүргэсэн хэрэгт буруутган, Галдан бишгийг хаанд тэднийг урвах санаатай гэж мэдүүлсэн байна. Бага хүрээний лам нар Зая Бандидын үеэс хошоодын Очирт сэцэн ханыг дотночилж хишигийг нь хүртэж ирснийг Галдан бишгийг хаан сайн мэдэж байсан бөгөөд Цэвээнравданд мэдээ хүргэсэн хэрэгт тэднийг ялласан байна. Юуны түрүүнд Төрхүү лам эрх цоржийг баривчилж цаазаар аваачих гэтэл тэр огт айж сурдсэнгүй харин **Миний хувилагч тэр минь амийг авагч эрлэг мөн. Ноён Гэлэнгийн хуурмаг буй зээ. Гэвч урьдын үйлээс давж болохгүй. Няцалгүй үхэх тойн хүмүүний үхэл мөн. Айхгүй, түргэл** (4.т.114.) гэжээ. Ингэхэд Галдан бишгийг шууд цаазлахаас татгалзаж чанд хорих ял оноожээ. Харин түүнтэй холбоотой 58 лам бандидыг урьд хожид яллуулан цаазлуулсан (4.т.114.) явдал нь Цэвээнравданд хорсон хорсloo гаргасан хэрэг байжээ.

1690 онд Галдан бишгийг хаан цэрэг морио тэгшилж, манжийн цэргийн эсрэг Улаан буданд түрэн орох үеийг ашиглан Цэвээнравдан цэрэглэн Ховдын суурин газрыг гэнэдүүлэн дайрч эм хүүхэд иргэдийг дуустал барьж аваачин түшиц газартай болов. 1691 онд цэрэг илгээж Сагил, Улаангом зэргийг байлдан авч эзэмшил нутгаа Эрчис голын дээд урсгалаас Увс нуур хүртэл тэлжээ (5.т.185.).

Цэвээнравдан Галдан бишгийг хүчирхэгжсэн нь Түүдийн шарын шашны этгээдийн анхаарлыг хэдийнээ татжээ. Дэсрид див Санжаажамц лам Галдан бишгийг дэмжиж ирсэн болохоор Цэвээнравдандаа удаа дараа элч зарж дайсагналцаа зогсоож эвсэхийг ятган зааварлаж байжээ (7.т.95.). Гэвч Цэвээнравдан огт зөвшөөрсөнгүйгээр барахгүй **Галдан хэрэв миний нутгийг шахамдуулахад хүрвэл Би эрхбиш бух хүчээр шүүрдэн арилгана** (7.т.186.) гэж хариулжээ. Галдан бишгийг хүртэл элч зарж эвлэрэхийг ятгасан боловч Див Санжаажамцын саналыг хэн хэн нь хүлээлгүй талаар болжээ.

Энэ үед Галдан бишгийг эв хүч өдрөөс өдөрт буурч байхад Цэвээнравдан харин улам бүр хүчирхэгжиж байжээ. Див Санжаажамцын хувьд манжийн дарангуйллын эсрэг тэмцэх гагц тулгуур хүчин нь Зүүн гарын улс байсан бөгөөд тэнд зөрчил хагарлын байдал тогтсон нь тун тааламжгүй байв. Тэр Цэвээнравдан Зүүн гар улсыг авч явж чадах цорын ганц хүчин болсныг ойлгож 1691 онд дэсрид див Санжаажамц Далай ламын нэрээр тамга бичиг ирүүлж **эрдэнэ зоригт хунтайж** цол соёрхжээ (7.т.95.). Энэ талаар И.Я. Златкин сонин санааг тэмдэглэсэн байна. Див Санжаажамц Галдан бишгийг Цэвээнравдан хоёр эвлэрэхгүй болохоор Зүүн гарын улсыг хоёр хэсэгт хуваан тус тус улс байгуулах, зүүн талын улсыг буюу ойрадын үндсэн нутаг дэвсгэрийг Цэвээнравдан, баруун буюу Ордосыг Галдан бишгийг хоёр хоюулаа зөвшөөрсөн бололтой. Тэгээд Див Санжаажамц Энх-Амгалан хаанаас манжийн цэргийг Ордосоос гаргах хүсэлт тавьжээ. Гэтэл манжийн Энх-Амгалан хаан Див Санжаажамцыг Галдандаа туслах гэж байгаад буруушааж цэргээ гаргасангүй явдлаар Див Санжаажамцын төлөвлөгөө нурсан байна.

Харин Див Санжаажамц Цэвээнравданг илт дэмжих болсон нь шарын шашны нэр нөлөө болон хүчийг нь ашиглан Зүүн гар улсаа мандуулахад нь асар сайхан бололцоо олгожээ.

1696 оны 5-р сард Галдан бишгийг цэрэгт хиар цохигдож дахин сэхээ авах найдваргүй болсон байв. Манжийн хаан Энх-Амгалан мөн оны 9-р сард Хөх хотод ирээд Хөх нуурын монгол тайж нарт Цэвээнравдантай **хүч хамжин Галданг барьтугай** (5.т.186.) гэсэн зарлиг буулгасан байна. Цэвээнравдан ч Цин улстай Зүүн гарын харилцааг зохицуулах, Галдан бишгийг дарахаар шийдэж манжийн Энх-Амгалантай түншлэх болов. Энх-Амгалантийн зарлигийн бичгийг хүлээн авмагцаа цэрэг дайчилж, тайж Эрхбаттай Алтайн ууланд болзож **Галданг хамтаар баривчлахад**

хүчээ өргөө (5.т.186.) гэж мэдэгджээ. Манжийн хаан ч Цэвээнравданыг ашиглан Галданыг бүр мөсөн сөнөөхийг эрмэлзэж, найр тавих болжээ.

1696 оны 6-р сард Галдан бошогт Тамир голын хөндийд зугатан ирэхэд хамтран зүтгэгчидээс Равдан, Данжил, Данзан-Омбо, Ялгасан хутугт нар хүрэлцэн очсон байна. Цэргийн ихэнх нь дайн байлдаанд алагдсан буюу манжид олзлогдсон, нилээд хэсэг нь Цэвээнравдантай нийлэхээр одсоноор 5000 цэрэгтэй үлджээ. Энд тэдний хооронд бас зөрчил гарч Галдан бошогт Данжилын хамт өрнө зүг хөдөлж, бусад нь Тамирт үлдэж байгаад удалгүй Цэвээнравданд дагажээ.

1696 оны 5-р сард Цэвээнравдангаас Нэнс ноёныг тусгайлан томилж манжийн хаанд нутгийн гаралтай бэлэг сэлт барьж **Галданы арилжаа хийлгэхээр дотоод (манжид – И.С.) газар томилсон уйгур худалдаачдыг уг газар нь буцааж болохгүй, тэд нарыг Илид хүргэх болбуу** (5.т.186.) гэж гүйжээ. Энх-Амгалан хаан тэр дор нь хариу зарлиг явуулсан нь **Мөхөс Би тухайн яаманд тушаан байцааж явуулаад чиний гүйсан ёсоор явуултугай** (5.т.186.) гэжээ.

Манжийн төрийн Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамнаас Цэвээнравдангаас Цин улсад арилжаа хийлгэхээр томилон ирүүлсэн хүмүүсийн тоог хэт олон болсны учир харгалзахад бэрхтэй гэж хаандаа айлтгаж, **хойшид Цэвээнравданы томилон ирүүлэх хүмүүсийг 200-гаас хэтрүүлэхгүйг хүснэ** (5.т.196.) гэж айлтгахад Энх-Амгалан хаан Цэвээнравданыг өөртөө татахыг санаархаж **Элч зарлагын хүмүүний тоог 300-гаар хязгаарлатугай** (5.т.196.) гэсэн зарлиг буулгажээ. Тэгээд Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хэрэг мэдэгч түшмэл Ян эү-г ойрадад элчээр томилж цэцэгт дурдан хорин дөрвөн бүхэл, мөнгөөр хийсэн цайны суулга болон цайны таваг тус бүр нэг, булган арьсаар хийсэн малгай нэг, хасын бүс нэг, мана могойн арьсаар хийсэн гутал болон оймс тус бүр нэжгээд хосыг Цэвээнравданд шагнажээ (5.т.196.).

Цэвээнравданд ирүүлсэн бичигтээ цаг алдалгүй газар газарт цэрэг илгээж Галданг амьдаар баривчилж над хургуул, цэргийг нь сөнөө. Хэрэв Галдан бошогт алагдвал толгойг нь ирүүл (3.т.312.) гэж байжээ. Хөх нуурын ноёдоос Галданы охин Зүнчхээг баривчилж Бээжинд тушаахыг шаардсан байна (3.т.312.).

1696 оны сүүлчээр Галдан бошогт цөөхөн хүчинтэй Түйн голд байрлахад Цэвээнравдан манжийн түшмэдтэй хамт цохигоор явжээ. Тэр зуур Сагс, Төгрөг гол хүрэхэд 20 гаруй хоногийн газар ойртож явахад нь Див Санжаажамцын элч Дархан эмч гүйцэн очиж Цэвээнравданг нутагтаа буцах мэдээ хүргэсэн байна (3.т.315.). Див Санжаажамц Галдан бошогтыг эхнээс аваад сүүлч хүртэл үнэхээр аврахыг бүхий л аргаар оролдсон боловч санасан нь бүтэхгүй байв. Цэвээнравдан ч жолоогоо буруулж Зүүн гар улсдаа буцжээ.

Галдан бошогт хаан 1688 оны 10-р сард цэргээ дагуулан нутгаасаа гарснаас хойш буцаж ирж чадалгүй байсаар 1697 оны 3-р сарын 13-ны өглөө Алтайн уулын Ац-Амтат газарт хор ууж 52 насандaa нас баржээ. Түүний харьяат нарын олонх нь Цэвээнравданг түшихээр ирсэнд илбэн тохинуулах газар олгосон байна (7.т.96.).

Галдан бошогтын түшмэл зайсан нар түүний хүүрийг Цин улсын цэргийн гарти оруулахгүйн тулд 1697 оны 3-р сарын 14-ний шөнө дөлөөр чандарлан тэнгэрт дэгдээж, чандрыг нь түүж авчээ (3.т.315.). Галданы шадар Данжил **Бошогт хааны чандар болон охин Зүнчхээг Далай ламын газарт хүргэвээс миний сэтгэл гүйцнэ** (5.т.187.) гэж шийдэж, 900 гаруй өрх харьяат иргэдээ дагуулж, Галдан бошогтын чандар болон охин Зүнчхээг авч Түвд орныг чиглэжээ. Гэтэл Хөх нуур, Түвд хүрэх замд манжийн цэрэг хөндлөлдсөн тул Ац-Амтатаас арваад өртөөний газар яваад Баян-Өндөр хэмээх газарт буужээ. Тэндээс цааш явах болопцоогүй болохоор Цэвээнравдантай нийлэхийг бодолхийтэл угаас Галдан бошогтын шудрага түшмэл явсан тул Цэвээнравдан түүнийг багтаахгүйгээс сэтгэлдээ болгоомжилсон байна. Шадар ноёд нь Энх-Амгалан хаанд дагаар орох нь зүйтэй хэмээн хүчлэн ятгасан учир Данжил арга буюу манжид дагахаар шийдэж, Чигэр зайсан зэрэг есөн хүнийг томилж Цин улсад дагаар орох чимээг хүргүүлжээ (5.т.187.).

Данжил Галдан бошогтын чандар болон түүний охин Зүнчхээг өөрийн биеэр Цэвээнравдандаа хүргэхээр Баян-Өндөрөөс гараад Богд эрээн хавиргын Жимс гэдэг газарт хүрчээ. Богд эрээн хавирга нь Зүүн гарг нэвтрэх чухал газар зүйн үүд хаалга болох бөгөөд Цэвээнравдан дүү Гуман ламыг томилон сэргийлэн суулгасан байв. Данжилыг ойртооныг мэдээд Гуман лам анги цэрэгтэй замыг нь хөндлөлдөхөд Данжилаас *Галдан бошогтын чандар болон охин Зүнчхээг Цэвээнравдан хаанд тушаавал миний сэтгэл гүйцнэ* (5.т.188.) гэж айлдажээ. Гуман лам дархан Гэлэнг Данжилын элч түгч Саарандаштай хамтаар Бор тал руу Цэвээнравдан хаан руу явуулав. Цэвээнравдан Их Цэрэндондов, Гуман лам нарт мянган цэрэг даалгаж Барс хелийн давааны ар дахь Жимс хэмээх газарт Данжилыг тосч авчээ (7.т.97.). Цэвээнравдан монгол ёс заншил, өөрийн ойр төрлөө хамгаалах үүднээс Галдан бошогтын чандар болон охин Зүнчхээг хүндэтгэн хүлээн авсны дээр Данзан-Омбо, Ялгасун хутугт, Үржжав, Саран, Аларбай, Эрдэнэ лам, Ноён гэлэн, Цэнбэцамба зэрэг Галдангийн шадар ноёд түшмэдийг дагаар ирснийг нь эрхшээлдээ багтаажээ (5.т.188.). Тэрээр Данжилын санасан сэтгэл гүйцэж харьят 79 хүмүүнээ дагуулан манжид дагахаар Хамилыг чиглэжээ.

Ийнхүү Цэвээнравданг Зүүн гар улсын хаан болсныг гадаад дотоодод сая л 1697 онд албан ёсоор хүлээсэн байна. Цэвээнравдан эцэг Сэнгэ хааны орыг нилээд бэрхшээл даван туулж байж олжээ. Галдан бошогт, Цэвээнравдан нарын зөрчил нь төрийн эрх мэдлийн төлөө л тэмцэл бөгөөд Цэвээнравдан ялах тавилантай байжээ. Галдан бошогт улс орондоо дайчин бодлого хэрэгжүүлж, ард түмэн нь байнга байлдаан самууны үймээнд өртөж байсны улмаас Цэвээнравданг гарч ирэхэд эсэргүүцэл гаргасангүй харин дэмжин захирагджээ. Нөгөөтэйгүүр Зүүн гар улсын эрх ямбатан нарын зөрчил хагарал туйлын хурцатсан байна.

How the Tseveenravdan crown-prince (khutugtu)became khan.

By Saruul.I.

This article touched the issues related with Mongolian Zuun Gariin Khanate and political activities of the Tseveenravdan. At that times in Zuun Gariin Khanate were at political crisis however Tseveenravdan khutagtu managed to stabilize the situation and became the khaan.

Ашигласан ном зохиол

1. “БНМАУ-ын түүх”. Боть П. – УБ., 1968.
2. Бадай, Алтан-Оргил, Эрдэнэ. Ойрадын түүхэн сурвалж бичиг. - Өвөр Монгол, 1985.
3. Златкин И.Я. История Джунгарского ханства /1635-1758/. – М., Наука, 1964.
4. Намсрай. Дайчин улсын үеийн Монголын түүх. - Улаанхад, 1993.
5. Алтаншаа Н. Ойрадын түүхэн дэх нэрт хүмүүс. - Өрөмч, 1995.
6. Саруул И. Цэвээнравдан хаан.- УБ., 2001.
7. Намсрай. Дервэн ойрадын түүх. - Хөх хот, 1992.
8. Гуревич Б.П. Международные отношения в Центральной Азии в ХУП в первой половине XIX в. Второе дополненное издание. - М., Наука, 1983.